

Онцгой байдлын үеийн хөнгөлөлт болон хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төслийн
Байгаль орчин ба нийгмийн нөлөөний үүрэг хариуцлагын төлөвлөгөө

Хөдөлмөр Нийгмийн Хамгааллын Яам

**Онцгой байдлын үеийн хөнгөлөлт болон
хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл
(P174116)**

**Байгаль орчин ба нийгмийн нөлөөний
үүрэг хариуцлагын төлөвлөгөө
(БОННХТ)**

Төсөл

2020 оны 5 сарын 20

БАЙГАЛЬ ОРЧИН БА НИЙГМИЙН НӨЛӨӨНИЙ ХАРИУЦЛАГЫН ТӨЛӨВЛӨГӨӨ (БОННХТ)

1. **Монгол Улс** (цаашид Хүлээн авагч гэх) нь Хөдөлмөр, Нийгмийн Хамгааллын Яам (ХНХЯ)-аар дамжуулан “Онцгой байдлын үеийн хөнгөлөлт болон хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл” (цаашид Төсөл гэх) хэрэгжүүлнэ. Олон Улсын Хөгжлийн Ассоциаци (цаашид Ассоциаци гэх) Төслийг санхүүжүүлэхээр тохиролцов.
2. Хүлээн авагч нь Төслийг Байгаль орчин, нийгмийн стандартад (**БОНС**) нийцүүлэн хэрэгжүүлэхийн тулд тодорхой арга хэмжээ, үйл ажиллагааг хэрэгжүүлнэ. Байгаль орчин, нийгмийн нөлөөний хариуцлагын төлөвлөгөө (**БОННХТ**) нь хэрэгжүүлэх бодит арга хэмжээ, үйл ажиллагаа, аливаа тодорхой баримт бичиг, төлөвлөгөө, түүнчлэн эдгээрийг хэрэгжүүлэх цаг хугацааг тусгасан байна.
3. Бодит арга хэмжээ, тодорхой үйл ажиллагааг ХНХЯ хэрэгжүүлэх хэдий ч БОННХТ-ний бүх шаардлагыг хангах үүргийг Хүлээн авагч хүлээнэ.
4. Хүлээн авагч нь БОННХТ-д тусгасан бодит арга хэмжээ болон үйл ажиллагааны хэрэгжилтэд тус төлөвлөгөөнд тусгасан шаардлага, санхүүжилтийн гэрээний нөхцөлийн дагуу хяналт тавьж Ассоциацид тайлагнах ба Ассоциаци нь төслийн хэрэгжилтийн явцад бодит арга хэмжээ, үйл ажиллагааны явц, гүйцэтгэлд хяналт тавьж, үнэлнэ.
5. Төслийн хэрэгжилтийн явцад гарах өөрчлөлт, урьдчилан тооцоолоогүй нөхцөл байдал үүсэх, эсвэл БОННХТ-ний хэрэгжилтийн хүрээнд төслийн гүйцэтгэлийг үнэлсэнтэй холбоотойгоор Ассоциаци болон Хүлээн авагч тохиролцсоны дагуу БОННХТ-г шинэчилж болно. Ийм тохиолдолд, уг төлөвлөгөөнд оруулах өөрчлөлтүүдийг Хүлээн авагч нь Ассоциацитай зөвшилцөж тохиролцсоны үндсэн дээр БОННХТ-нд тэдгээр өөрчлөлтийг тусгана. БОННХТ-нд оруулахаар харилцан тохирсон өөрчлөлтийн талаар Ассоциаци болон Хүлээн авагч хооронд гарын үсэг бүхий албан бичиг солилцож баримтжуулна. Хүлээн авагч нь шинэчилсэн БОННХТ-г нэн дариу олон нийтэд ил тод мэдээлнэ.
6. Төслийн хэрэгжилтийн явцад гарсан Төслийн өөрчлөлт, урьдчилан тооцоолоогүй нөхцөл байдал эсвэл төслийн гүйцэтгэл, эрсдэл, үр нөлөөний өөрчлөлтийн үед Хүлээн авагч шаардлагатай гэж үзвэл ийм эрсдэл, нөлөөллийг арилгах арга хэмжээ, үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд шаардагдах нэмэлт санхүүжилт гаргана.

Онцгой байдлын үеийн хөнгөлөлт болон хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төслийн
Байгаль орчин ба нийгмийн нөлөөллийн үүрэг хариуцлагын төлөвлөгөө

БОДИТ АРГА ХЭМЖЭЭ, ҮЙЛ АЖИЛЛАГАА		ХУГАЦАА	Хариуцах байгууллага/ Эрх бүхий байгууллага
ХЯНАЛТ БОЛОН ТАЙЛАГНАЛТ			
А	ТОГТМОЛ ТАЙЛАН: Төслийн гүйцэтгэлийн байгаль орчин, нийгэм, эрүүл мэнд, аюулгүй ажиллагаанд хяналт шинжилгээ хийж, тогтмол хугацаанд Ассоциацид ирүүлэх тайланд БОННХТ-ний хэрэгжилт, байгаль орчин, нийгмийн нөлөөний баримт бичгүүдийн боловсруулалт, хэрэгжилтийн явц (үүний дотор Байгаль орчин, нийгмийн удирдлагын хүрээ (БОНУХ), оролцогч талуудын оролцооны төлөвлөгөө (ОТОТ), БОННХТ-нд тусгагдсан байгаль орчин, нийгмийн нөлөөний удирдлагын тогтолцоо (БОННУТ), оролцогч талуудын оролцоог хангах үйл ажиллагаа, өргөдөл гомдлын бүртгэл зэргийг тусгасан байна.	Төслийн хэрэгжилтийн хугацаанд, 6 сар тутам.	ХНХЯ/ТХН
В	ТОХИОЛДОЛ БА ОСОЛ: Хүрээлэн буй орчин, нийгэм, олон нийт болон ажиллагсдад ихээхэн сөрөг нөлөө үзүүлсэн эсвэл үзүүлж болзошгүй аливаа байгаль орчин, нийгмийн сөрөг нөлөөний тохиолдол, осол гарсан тохиолдолд Ассоциацид нэн даруй мэдэгдэнэ. Тухайн тохиолдол эсвэл ослын талаарх дэлгэрэнгүй мэдээллийг өгөхийн зэрэгцээ тухайн тохиолдолд авсан эсвэл авахаар төлөвлөж буй арга хэмжээ, мөн холбогдох гэрээлэгч, удирдах эрх бүхий байгууллагаас зохих ёсоор ирүүлсэн бүхий л мэдээллийг Ассоциацид ирүүлнэ. Улмаар Ассоциацийн хүсэлтийн дагуу тухайн тохиолдол эсвэл ослын талаар тайлан бэлтгэж, тухайн төрлийн тохиолдол, осол дахин гарахаас урьдчилан сэргийлэх аливаа арга хэмжээг санал болгоно.	Аливаа тохиолдол/ослын талаар мэдсэнээс хойш 48 цагийн дотор Ассоциацид мэдэгдэх.	ХНХЯ/ТХН
БОНС 1: БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГМИЙН ЭРСДЭЛ, ҮР НӨЛӨӨНИЙ ҮНЭЛГЭЭ, УДИРДАГА			
1.1	БАЙГУУЛЛАГЫН БҮТЭЦ: Хөдөлмөр, Нийгмийн Хамгааллын Яам (ХНХЯ) нь Төсөл Хэрэгжүүлэх Нэгжийг (ТХН)-ийг Төслийн гүйцэтгэлийн байгаль орчин, нийгэм, эрүүл мэнд, аюулгүй ажиллагааны эрсдэл, нөлөөллийг удирдахад дэмжлэг үзүүлэх чадварлаг ажилтан, нөөцөөр хангана.	Төслийн хэрэгжилтийн хугацаанд байгууллагын бүтэц, чадварлаг ажилтнуудаар ханган ажиллана.	ХНХЯ

Онцгой байдлын үеийн хөнгөлөлт болон хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төслийн
Байгаль орчин ба нийгмийн нөлөөллийн үүрэг хариуцлагын төлөвлөгөө

БОДИТ АРГА ХЭМЖЭЭ, ҮЙЛ АЖИЛЛАГАА	ХУГАЦАА	Хариуцах байгууллага/ Эрх бүхий байгууллага
<p>1.2 БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГМИЙН ҮНЭЛГЭЭ БОЛОН УДИРДЛАГЫН ТӨЛӨВЛӨГӨӨ, ГЭРЭЭ БАРИМТ БИЧИГ/ГЭРЭЭЛЭГЧ</p> <p>a. Төслийн үйл ажиллагааг хэрэгжүүлж эхлэхээс өмнө Хүлээн авагч тал Төслийн үйл ажиллагааны байгаль орчин, нийгмийн эрсдэл, нөлөөний үнэлгээг Байгаль орчин, нийгмийн удирдлагын хүрээ (БОНУХ)-нд заасны дагуу бэлтгэн, Ассоциациар хянуулж дэмжүүлсэн байна. БОНУХ нь тодорхой нөхцөл байдлаас шалтгаалан орхигдож болзошгүй эсвэл эмзэг бүлгийн хувь хүн, бүлгүүд төслийн үр дүнд бий болох хөгжлийн үр шимийг хүртэх боломжийг бүрдүүлэх арга хэмжээг тусгана. Үүнд: (i) асбестын удирдлагын төлөвлөгөө; (ii) COVID-19 цар тахлаас ажиллагсад болон олон нийтийг хамгаалах эрүүл мэнд, аюулгүй байдлын арга хэмжээ; ба (iii) ХНХЯ ба ТХН-ийн ажилтнуудыг тухайн Төслийн БОННХ-ний асуудлаар тухайлан сургах, чадавх бэхжүүлэх төлөвлөгөө.</p> <p>b. Үнэлгээнд тулгуурлан Төслийн үйл ажиллагаатай холбоотой байгаль орчин, нийгмийн удирдлагын аливаа төлөвлөгөө эсвэл бусад шаардлагатай баримт бичгийг Байгаль орчин, нийгмийн стандартууд (БОНС), БОНУХ, Байгаль орчин, эрүүл мэнд, аюулгүй байдлын удирдамжууд болон бусад Аж үйлдвэрийн олон улсын сайн туршлага (GIP), ДЭМБ-ын COVID-19 цар тахлын үед баримтлах удирдамжийн дагуу Ассоциацид хүлээн зөвшөөрөгдөх арга хэлбэрээр бэлтгэж, мэдээлж, баталж хэрэгжүүлнэ.</p> <p>c. БОННХТ-нд хамааралтай асуудлууд, тухайлбал байгаль орчин, нийгмийн удирдлагын төлөвлөгөө (БОНУТ) эсвэл бусад баримт бичиг, БОНС -2 шаардлагууд, бусад шаардлагатай байгаль орчин нийгэм, эрүүл мэнд, аюулгүй ажиллагааны арга хэмжээг худалдан авах ажиллагааны баримт бичгийн байгаль орчин нийгэм, эрүүл мэнд, аюулгүй ажиллагааны стандартын заалт, гэрээт байгууллагууд болон хяналт удирдлагын компаниудтай байгуулсан гэрээнд тусгах. Ингэснээр гэрээт гүйцэтгэгч компаниуд болон хяналт удирдлагын компаниуд тус тусын гэрээг хэрэгжүүлэхдээ байгаль орчин нийгэм, эрүүл мэнд, аюулгүй ажиллагааны стандартын заалтыг биелүүлэн хангаж ажиллах нөхцөл бүрдэнэ.</p> <p>d. Төслийн Үйл ажиллагааны гарын авлага болон ХЭДС-гийн гарын авлагад нэмэлт өөрчлөлт оруулж, байгаль орчин болон нийгмийн нөлөөллийн асуудлаарх өндөржсөн хариуцлагыг тусгана.</p>	<p>a. Холбогдох Төслийн үйл ажиллагааг хэрэгжүүлж эхлэхээс өмнө.</p> <p>b. Холбогдох Төслийн үйл ажиллагааг хэрэгжүүлж эхлэхээс өмнө болон хэрэгжүүлэх бүхий л хугацааны турш.</p> <p>c. Холбогдох төслийн үйл ажиллагааны худалдан авах ажиллагааг эхлэхээс өмнө болон хэрэгжүүлэх бүхий л хугацааны турш.</p> <p>d. Холбогдох төслийн үйл ажиллагааны худалдан авах ажиллагааг эхлэхээс өмнө болон хэрэгжүүлэх бүхий л хугацааны турш</p>	<p>ХНХЯ/ТХН</p>

Онцгой байдлын үеийн хөнгөлөлт болон хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төслийн
Байгаль орчин ба нийгмийн нөлөөллийн үүрэг хариуцлагын төлөвлөгөө

БОДИТ АРГА ХЭМЖЭЭ БОЛОН ҮЙЛ АЖИЛЛАГАА		ХУГАЦАА	Хариуцах байгууллага/ Эрх бүхий байгууллага
1.3	<p>ХОРИГЛОХ ҮЙЛ АЖИЛЛАГАА: Төслийн хүрээнд дараах төрлийн үйл ажиллагааг санхүүжүүлэхгүй:</p> <ul style="list-style-type: none"> • Байгаль орчинд урт хугацааны, байнгын эсвэл буцааж сэргээх боломжгүй сөрөг үр дагаварт хүргэж болзошгүй үйл ажиллагаа; • Хүний эрүүл мэндэд ноцтой сөрөг нөлөө үзүүлэх өндөр магадлалтай үйл ажиллагаа; • Чухал амьд биет, ургамал орчинд ноцтой сөрөг нөлөө үзүүлж болзошгүй үйл ажиллагаа; • Нийгэмд ихээхэн сөрөг нөлөө үзүүлж болзошгүй болон нийгмийн зөрчилдөөнд хүргэж болзошгүй үйл ажиллагаа; • Нутгийн иргэд эсвэл эмзэг бүлгийн цөөнхийн газар нутаг, эрхэнд нөлөөлж болзошгүй үйл ажиллагаа; • Аливаа нүүлгэн шилжүүлэлт, газар чөлөөлөлт/газар ашиглалтыг хязгаарлах эсвэл соёлын өвд сөрөг нөлөө үзүүлэх үйл ажиллагаа; • Төслийн Байгаль орчин, нийгмийн удирдлагын хүрээнд хориглосон бусад бүх үйл ажиллагаа. 	Дээр дурдсан 1.2.а –гийн хүрээнд зохион байгуулах үнэлгээний үйл явцад.	ХНХЯ/ТХН
1.4	Асбестын талбайн хяналт шинжилгээ, магадлалыг Аж үйлдвэрийн олон улсын сайн туршлагад (GIP) нийцүүлэн гүйцэтгэнэ.	Хөдөлмөр, Халамжийн Үйлчилгээний Ерөнхий Газрын (ХХҮЕГ) засварын ажлын төлөвлөхөөс өмнө.	ХНХЯ/ТХН
1.5	Бүрэлдэхүүн 2-ын хүрээнд бичил аж ахуйн нэгжүүдийг сонгохдоо Байгаль орчин, нийгмийн удирдлагын хүрээнд жагсаасан байгаль орчин, нийгмийн шалгуур үзүүлэлт хангасан эсэхийг шалгана.	Төсөл хэрэгжүүлэх хугацаанд	ХНХЯ/ТХН
БОНС 2: АЖИЛЛАХ ХҮЧ БОЛОН АЖЛЫН НӨХЦӨЛ			
2.1	Хөдөлмөрийн удирдлага: Төсөл нь БОНС-2-ын холбогдох шаардлагын дагуу Ассоциацид хүлээн зөвшөөрөгдөх арга хэлбэрээр тухайлбал хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй ажиллагааны зохих арга хэмжээг хэрэгжүүлэх (яаралтай тусламжийн бэлэн байдал, хариу арга хэмжээг оролцуулан), төслийн ажиллагсдын өргөдөл гомдлыг зохицуулах арга хэмжээг тогтоох, хөдөлмөрийн шаардлагыг худалдан авах ажиллагааны баримт бичгийн байгаль орчин нийгэм, эрүүл мэнд, аюулгүй ажиллагааны стандартын заалтыг гэрээт байгууллагууд болон хяналт удирдлагын компаниудтай байгуулсан гэрээнд тус тус тусгах ажлыг зохион байгуулна.	Төсөл хэрэгжүүлэх хугацаанд	ХНХЯ/ТХН
2.2	Хүлээн авагч нь ажиллах хүчний удирдлагын төлөвлөгөөг (АХҮТ) Ассоциацид хүлээн зөвшөөрөгдөх арга хэлбэрээр бэлтгэн боловсруулж, баталж, хэрэгжүүлнэ.	Ажиллах хүчний удирдлагын төлөвлөгөөг ажиллагсад Төслийн үйл ажиллагаанд оролцож эхлэхээс өмнө баталж төсөл хэрэгжүүлэх хугацааны турш мөрдөнө	ХНХЯ

Онцгой байдлын үеийн хөнгөлөлт болон хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төслийн
Байгаль орчин ба нийгмийн нөлөөллийн үүрэг хариуцлагын төлөвлөгөө

БОДИТ АРГА ХЭМЖЭЭ БОЛОН ҮЙЛ АЖИЛЛАГАА		ХУГАЦАА	Хариуцах байгууллага/ Эрх бүхий байгууллага
2.3	Хүлээн авагч нь хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдлын зохих арга хэмжээг (яаралтай тусламжийн бэлэн байдал, хариу арга хэмжээг оролцуулан) Төслийн бүхий л байгууламжид БОНУХ, БОНС-2-ын холбогдох шаардлагууд, Байгаль орчин, нийгэм, эрүүл мэндийн удирдамжууд, ДЭМБ-ын COVID-19 цар тахлын үед баримтлах удирдамж гэх мэт Аж үйлдвэрийн олон улсын сайн туршлагад (GIP) нийцүүлэн хэрэгжүүлнэ.	Төсөл хугацаанд хэрэгжүүлэх	ХНХЯ/ТХН
БОНС 3: НӨӨЦИЙН ҮР АШИГ, БОХИРДЛООС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ БОЛОН МЕНЕЖМЕНТ			
3.1	Энэ стандартын холбогдох асуудлуудыг, тухайлбал Эрүүл мэндийн үйлчилгээний хог хаягдал, асбест агуулсан материал, бусад төрлийн хортой болон хоргүй хог хаягдлыг удирдах арга хэмжээг, шаардлагатай бол дээрх 1.2-т заасан арга хэмжээний хүрээнд авч үзнэ. Бичил бизнесийн байгаль орчинд үзүүлэх эрсдэлийн шалгуураар шүүх шатыг БОНУХ ба БОНУТ-нд заасны дагуу хийх бөгөөд үйл ажиллагаа нь байгаль орчныг бохирдуулах өндөр магадлалтай бичил бизнесийг дэмжихгүй, хасна. Мөн дээрх шалгуурыг хийхдээ бичил бизнесийн үйл ажиллагаанд БОНС-3-той холбоотой асуудал байгаа эсэхийг тодорхойлж, тодорхой цаг хугацаатай арга хэмжээний төлөвлөгөөг (БОННХТ-ий хэлбэрээр) холбогдох бичил бизнесийн төлөөлөлтэй хамтран гаргаж зөвшилцөх бөгөөд тэдгээр нь Монгол улсын утааны найрлага дахь хорт бодисын зөвшөөрөгдөх хэмжээний тухай стандарт, Дэлхийн Банкны ерөнхий болон тухайн салбарт хамаарах Байгаль орчин, эрүүл мэнд, нийгмийн удирдамжийн шаардлагад нийцсэн байх ёстой.		
БОНС 4: ОЛОН НИЙТИЙН ЭРҮҮЛ МЭНД, АЮУЛГҮЙ БАЙДАЛ			
4.1	Энэ стандартын холбогдох асуудлуудыг, тухайлбал шаардлагатай бол дээрх 1.2-т заасан арга хэмжээний хүрээнд авч үзнэ. Үүнд: олон нийтийн дунд халдварт өвчин тархах магадлалыг бууруулах; тодорхой нөхцөл байдлаас шалтгаалан орхигдож болзошгүй эсвэл эмзэг бүлгийн хувь хүн, бүлгүүд Төслийн үр дүнд бий болох хөгжлийн үр шимийг хүртэх боломжийг хангаж баталгаажуулах; хамгаалалтын албаны үйлчилгээ хэрэглэхтэй үүсэх эрсдэлийг удирдах; хөдөлмөрийн дотогш чиглэсэн урсгалын эрсдэлийг удирдах; ба бэлгийн дарамт, бэлгийн хүчирхийлэл, мөлжлөгөөс урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах.		
БОНС 5: ГАЗАР ЧӨЛӨӨЛӨХ, ГАЗАР АШИГЛАХ БОЛОН АЛБАДАН НҮҮЛГЭХ ХЯЗГААРЛАЛТУУД			
5.1	Хамааралгүй.		
БОНС 6: БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫН ХАМГААЛАЛ БОЛОН АМЬД БАЙГАЛИЙН НӨӨЦИЙН ТОГТВОРТОЙ МЕНЕЖМЕНТ			
6.1	Шаардлагатай бол энэ стандартад хамааралтай асуудлуудыг үйл ажиллагаа 1.2-н хүрээнд авч үзнэ. Төслийн хүрээнд санхүүжүүлэхгүй хориглох шалгуур үзүүлэлтийг чухал амьтад, биетэд сөргөөр нөлөөлөхөөс зайлсхийж Байгаль орчин, нийгмийн удирдлагын хүрээ ба Байгаль орчин, нийгмийн удирдлагын тогтолцоонд тусгах нь зүйтэй. Дэд төслүүдийг шалгаруулах явцад биологийн төрөл зүйл, чухал-бус байгалийн амьд биетэд аливаа сөрөг нөлөө үзүүлж болзошгүй нь тогтоогдвол дэд төслүүдийн байгаль орчны нөлөөний үнэлгээний нэг хэсэг болгон эдгээр сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээг боловсруулж хэрэгжүүлнэ.		
БОНС 7: НУТГИЙН ИРГЭД /АФРИКИЙН САХАР ОРЧМЫН БУС НУТГИЙН НУТГИЙН ИРГЭД			
7.1	Энэ стандартын холбогдох асуудлуудыг, тухайлбал шаардлагатай бол дээрх 1.2-т заасан арга хэмжээний хүрээнд авч үзнэ.		
БОНС 8: СОЁЛЫН ӨВ			
8.1	Энэ стандартын холбогдох асуудлуудыг, тухайлбал шаардлагатай бол дээрх 1.2-т заасан арга хэмжээний хүрээнд авч үзнэ.		
БОНС 9: САНХҮҮГИЙН ЗУУЧЛАЛ			

Онцгой байдлын үеийн хөнгөлөлт болон хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төслийн
Байгаль орчин ба нийгмийн нөлөөллийн үүрэг хариуцлагын төлөвлөгөө

БОДИТ АРГА ХЭМЖЭЭ БОЛОН ҮЙЛ АЖИЛЛАГАА		ХУГАЦАА	Хариуцах байгууллага/ Эрх бүхий байгууллага
9.1	Энэ стандартын холбогдох асуудлуудыг, тухайлбал шаардлагатай бол дээрх 1.2-т заасан арга хэмжээний хүрээнд авч үзнэ. Оролцогч санхүүгийн байгууллага (ОСБ) тус бүр Төслөөс санхүүжүүлэх аливаа үйл ажиллагаатай холбоотой Байгаль орчин, нийгмийн эрсдэлийн түвшнээс хамааруулан БОНУТ-г бий болгож нэвтрүүлэх бөгөөд энэ нь дэд төслүүдэд мөн үйлчилнэ. ОСБ нь БОНУТ-г хэрэгжүүлэхэд шаардлагатай институцын зохион байгуулалтыг хийх, үүний дотор дэд төслүүдийн байгаль орчин, нийгмийн нөлөөний асуудлыг хариуцах үүрэг хариуцлага бүхий удирдах тушаалтныг томилон ажиллуулна. ОСБ -ын төлөөлөгч нь орон нутгийн хөдөлмөр, нийгмийн халамжийн газар, хэлтсийн байгуулсан сонгон шалгаруулах хэсгийн гишүүнээр ажиллана. ОСБ болон дэд төсөл хэрэгжүүлэх бичил бизнесүүд нь БОНУТ ба БОНС-2-ын шаардлагад нийцсэн хөдөлмөрийн удирдлагын журмыг боловсруулж ашиглах бөгөөд үүнд ажилчдын өргөдөл гомдлыг барагдуулах механизмыг тусгасан байна.		
БОНС 10: ОРОЛЦОГЧ ТАЛУУДЫН ОРОЛЦОО БОЛОН МЭДЭЭЛЛИЙГ ИЛ ТОД БОЛГОХ			
10.1	ТАЛУУДЫН ОРОЛЦООГ ХАНГАХ ТӨЛӨВЛӨГӨӨ: Оролцогч талуудын оролцоог хангах төлөвлөгөөг (ОТОХТ) БОНС 10-т нийцүүлэн Ассоциацид хүлээн зөвшөөрөгдөх арга хэлбэрээр шинэчилж, олон нийтэд ил тод мэдээлж, баталж хэрэгжүүлнэ. Ялангуяа ХНХЯ нь ТХН болон орон нутгийн хөдөлмөр халамжийн үйлчилгээний газар, хэлтсүүдтэй хамтран, ОТОХТ-г шинэчлэн хэрэгжүүлж, шаардлагатай санхүүгийн эх үүсвэрийг Төслөөс хуваарилуулж ажиллана. Мөн ТХН нь БОНС 10-г хэрэгжүүлэхийн тулд орон нутгийн хөдөлмөр халамжийн үйлчилгээний газар хэлтсүүдийн ажилтнуудын сургалтыг төлөвлөх, хэрэгжүүлэхэд шаардлагатай техникийн мэргэжилтнийг түр хугацааны гэрээний үндсэн дээр авч ажиллуулна.	ОТОХТ -ний төслийг боловсруулсан бөгөөд Төсөл хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш 30 хоногоос хэтрэхгүй хугацаанд шинэчилж олон нийтэд ил тод мэдээлнэ. ОТОХТ-г төсөл хэрэгжүүлэх бүх хугацаанд хэрэгжүүлнэ.	ХНХЯ/ТХН
10.2	ГОМДОЛ БАРАГДУУЛАХ МЕХАНИЗМ: Төсөлтэй холбоотой асуудал, өргөдөл гомдлыг хүлээн авч, шийдвэрлэх зорилгоор гомдол барагдуулах хүртээмжтэй зохицуулалтыг БОНС 10-т нийцүүлэн, Ассоциацид хүлээн зөвшөөрөгдөх арга хэлбэрээр олон нийтэд хүртээмжтэй, нээлттэй болгох.	Төсөл хэрэгжүүлэх хугацаанд.	ХНХЯ/ТХН
ЧАДАВХИ БЭХЖҮҮЛЭХ (СУРГАЛТ)			
CS1	Дараах сэдвээр ХНХЯ, ТХН ба ОСБ-ын ажилтнуудыг сургах: <ul style="list-style-type: none"> • Дэлхийн банкны Байгаль орчин, нийгмийн хүрээ (БОНХ); • БОНУХ-нд заасны дагуу байгаль орчин, нийгмийн удирдлагын журам процедур (дэд төсөл шалгаруулах, боловсруулах, батлах, хэрэгжүүлэх хугацааны туршид); • ОНОХТ-д туссаны дагуу оролцогч талуудыг тодорхойлох, оролцоог төлөвлөх. 	Төсөл хэрэгжүүлэх хугацаанд.	ХНХЯ/ТХН
CS2	Гэрээлэгч байгууллага, ажилчид, хяналт хариуцсан зөвлөхүүд болон холбогдох албан тушаалтнуудыг асбестын удирдлага ба хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдлын талаар сургалтад хамруулах.	Төсөл хэрэгжүүлэх хугацаанд.	ХНХЯ/ТХН
CS3	Төслийн хэрэгжилтэд оролцож буй бүх ажилтнуудад дараах сэдвээр сургалт явуулна. Үүнд: <ul style="list-style-type: none"> • COVID-19 цар тахлын халдвараас урьдчилан сэргийлэх, хянах ДЭМБ-ын удирдамж; • Эрсдэлийн талаарх мэдээлэл харилцаа ба олон нийтийн оролцоог хангах; 	Төсөл хэрэгжүүлэх хугацаанд.	ХНХЯ/ТХН